



VII АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Анги: Овог: Нэр:

ХУВИЛБАР А

ХУГАЦАА 60 МИНУТ

МАНЖАА /ХӨРӨГ НАЙРУУЛАЛ/

Манжаагийн уг нэр нь Манал. Гэвч миний л мэдэхийн толгойтой болгон Манжаа Манжаа гэгцээдэг байлаа. Хүүхдээс өндөргүй, өөртөө томдсон эзтэн монгол гутал элбэгдсэн дээлтэй Манжаа минь. Навсгар жаахан Манжаа элбэгдсэн дээл томдсон гуталтайгаа зогсож байх нь модоор зорсон монгол шатрын ноёнорхуу бас ч хэвлүү. Дээр нь нэг онцлог түүнд байжээ, одоо бодоход. Хүн бүр тэр үед "Бидний монгол эзэн Чингисийн үеэс эхлээд" гэж хэлж байсангүй. Манжаа л хэлнэ. Айл саахалтын адууны хөөгүүд, хурга тугалаас хэтрээгүй муу сайн дудрай хүүхдийг ч залуу юм, бага юм гэж чамлахгүй, өглөөний адуу оройтуулах, хурга нийлүүлэх зэрэгт "Манай монгол эзэн Чингисийн үеэс малаа малласаар ирсэн байтал чи явсан...." энэ тэр гэх мэтээр загнаж дуулдана.

ЭХ ДЭЭР ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР: НИЙТ ОНОО-10

1. Эхийн гол санааг зөв тодорхойлсон хэсгийг олоорой. /2 оноо/

А.Монголчуудын мал маллах арга ухаан Б.Манжаагийн тухай

В.Монголчуудын тухай

Г.Малчдын амьдралын тухай /

2. Дараах энгийн өгүүлбэрийг ЗНӨ болгон бүтээгээрэй. /2 оноо/

Хөвөн цагван үүл хэсэг хэсгээр нүүв. Намрын салхи сэр сэр салхилна.

.....
.....
.....

3. Эхээс гадаад, дотоод шинжийг илэрхийлсэн үг тус бүр 2-ыг олж бичээрэй.

.....
.....



VII АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Анги: Овог:..... Нэр:

ХУВИЛБАР Б

ХУГАЦАА 60 МИНУТ

МИНИЙ ААВ /ХӨРӨГ НАЙРУУЛАЛ/

Тээврийн замын энхэл донхол бартваг тоочоод барах юун. Өгсөнө, уруудна, дээшилнэ, доошилно, өчнөөн төчнөөн даваа нугачааг давна. Бартва ихтэй замыг хэрхэн туулж, зорьсон газраа зоволгүй хүрэх нь жолоочийн ур чадвар, ухаан сорьсон ажил. Гэтэл амьдралын зам түүнтэй ив ижилхэн ажээ. Даваа нугачаа, хүнд бэрх, энхэл донхол бүхэн тулаад ирэхэд туулаад гарах билиг ухааныг амьдралаа жолоодон яваа жолоочоос хорвоо өөрөө шаарддаг жамтай.

Өдрөөс өдөрт нуруу нь бөгтийж, өтгөн шаргал үс нь бууралтсан ч амьдралын нугачаанд эр зориг, эрмэг сэтгэл, бялхсан хайр юугаан гээгээгүй буурал аав минь ямар ч ажлыг хэцүү гэлгүй хийж, үр хүүхэд биднийхээ төлөө жолоо мушгиж амьдралынхаа замыг зурдаг байсан. Хөрөг юүгээн бичиж хөлийн тань дор дэвсжү хэмээн хорин жил хайранд тань өссөн охин чинь сэтгэлийн хэдэн үгээ цагаан цаасан дээр хэлхэн байна. Миний амьдралд гэгээн бүхнийг эхлүүлсэн хайрт аавыгаа би өндрөөс өндөрт өргөж, ачлах ёстой.

ЭХ ДЭЭР ГҮЙЦЭТГЭХ ДААЛГАВАР: НИЙТ ОНОО-10

1. Эхийн гол санааг зөв тодорхойлсон хэсгийг олоорой. /2 оноо/
 - А.Миний амьдралд гэгээн бүхнийг эхлүүлсэн хайрт аавыгаа би өндрөөс өндөрт өргөж, ачлах ёстой.
 - Б. Тээврийн замын энхэл донхол бартваг тоочоод барах юун.
 - В. Гэтэл амьдралын зам түүнтэй ив ижилхэн ажээ.
 - Г.Амьдралын нугачаанд эр зориг, эрмэг сэтгэл, бялхсан хайр юугаан гээгээгүй буурал аав минь.

2. Дараах энгийн өгүүлбэрийг ЗНӨ болгон бүтээгээрэй. /2 оноо/

Саврал шувууд усан дээгүүр жиргэлдэн нисэв. Загас жараахай энд тэнд пол пол хийж байна

3. Эхээс гадаад, дотоод шинжийг илэрхийлсэн үг тус бүр 2-ыг олж бичээрэй. /2оноо/

4. Дараах өгүүлбэрээс алдаатай үгсийг олж, алдааг засаж бичээрэй. /2 оноо/
 Даваа нугчаа, хүнд бэрэх, энхэл донхол бүхэн тулаад ирхэд туулаад гарах билиг
 ухааныг амьдралаа жолоодон яваа жолоочоос хорвоо өөрөө шаардадаг жамтай.

	Алдаатай үг	Залруулсан нь
1		
2		
3		
4		

5. Дараах үгийг бүтээврээр задалж, тайлбарлан бичээрэй. /2 оноо/
ЖОЛООЧИЙН

6. Өгүүлбэрийг кирилл бичигт хөрвүүлж бичээрэй. /5 оноо/

1. Өмнөд талд байгаа хэдхэн үеийнхэн нь
 2. Өмнөд талд байгаа хэдхэн үеийнхэн нь
 3. Өмнөд талд байгаа хэдхэн үеийнхэн нь
 4. Өмнөд талд байгаа хэдхэн үеийнхэн нь
 5. Өмнөд талд байгаа хэдхэн үеийнхэн нь
 6. Өмнөд талд байгаа хэдхэн үеийнхэн нь
 7. Өмнөд талд байгаа хэдхэн үеийнхэн нь
 8. Өмнөд талд байгаа хэдхэн үеийнхэн нь
 9. Өмнөд талд байгаа хэдхэн үеийнхэн нь
 10. Өмнөд талд байгаа хэдхэн үеийнхэн нь

7. УРАН ЗОХИОЛ

. П.Пүрэвсүрэн "БУРХАНБОГД ААВ ХОЁР" өгүүллэгийн гол дүр Бурханбогд хүүгийн
 дүрийн талаар мэдрэмж, сэтгэгдлээ уран дүрслэл ашиглан 3-5 өгүүлбэрт багтаан
 бичнэ үү?

.....

.....

.....